

МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А-163

Улаанбаатар хот

Түр журам, аргачлал батлах тухай

"Газрын тухай хууль"-ийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилт"-ын 3.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын элэгдэл /эвдрэл/, цөлжилтийн төлөв байдлыг үнэлэх, тайлан гаргах үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг 1 дүгээр, "Цөлжилтийн үнэлгээ хийх түр аргачлал"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. "Цөлжилтийн төлөв байдлын үнэлгээ хийх түр аргачлал"-ыг турших ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын сүлжээнд тулгуурлан гүйцэтгэхийг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшинд даалгасугай.

3. Түр журам, аргачлалыг туршсан ажлын дүнг 2010 оны 11 дүгээр сард Сайдын зөвлөлийн хуралд танилцуулахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-30 дугаар тушаалаар байгуулагдсан "Газрын элэгдэл, эвдрэлийн зэрэглэл, цөлжилтийн төрөл ангилал тогтоох, тэдгээртэй тэмцэх, нөхөн сэргээх журмыг боловсруулах" Ажлын хэсгийн ахлагч /Ц.Банзрагч/ нарт даалгасугай.

САЙД

Л. ГАНСҮХ